

Боловсролын байгууллага үүргээ биелүүлээгүй тохиолдолд суралцагчид үзүүлэх дэмжлэг



Таны элссэн суралцаж буй боловсролын байгууллага нь

- хаагдах, таны элссэн курсыг нээх боломжгүй болох, эсвэл таны элсэн суралцаж буй курсыг дундаас нь үргэлжлүүлэх боломжгүй болох мөн түүнчлэн
- тэд таны төлсөн сургалтын төлбөрийг буцаан олгох чадамжгүй болох эсвэл буцаан олголт хийхгүй удаах, эсвэл өөр боловсролын байгууллагат шилжүүлэн таныг сургалтаа үргэлжлүүлэх боломжоор хангахгүй байх тохиолдолуудыг.

Манай Сургалтын Төлбөр Хамгаалах Үйлчилгээний Албанаас **Боловсрол олгогч үүргээ биелүүлээгүй** гэж үзнэ.



Сургалтын Төлбөр Хамгаалах Үйлчилгээний Албанаас /TPS таны анх элсэхдээ бүртгүүлсэн холбоо барих хаягаар тантай холбогдоно.



TPS нь таныг мэдээлэл өгөх семинарт хүрэлцэн ирэхийг урих ба уг уулзалтаар цаашид юу хийх талаар болон TPS Онлайн Кейс Менежментийн системийг хэрхэн ашиглахыг талаар зөвлөгөө өгөх болно.

TPS -ээс танд Онлайн Кейс Менежментийн системд хэрхэн нэвтрэх мэдээлэл бүхий емэйл илгээнэ. Та TPS Онлайн системд www.tps.gov.au холбоосоор нэвтрэнэ.



Та TPS Online-д нэвтэрнэ үү.

TPS Онлайнд нэвтэрмэгцээ **та** нууц үгээ шинэчлэх, танд боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллага таны өмнө хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэхийг мэдэгдэх, өөрийн баримт бичгийн зураг (паспорт эсвэл жолооны үнэмлэх) оруулахаас гадна холбоо барих мэдээллээ шинэчлэх оруулах шаардлагатай.



TPS зүгээс танд тохирсон өөр боловсролын байгууллагад шилжин суралцах эсвэл элсэн орох байгууллага хайж олоход тань туслах боломжтой.



Хэрэв тохирсон өөр байгууллага олдохгүй бол эсвэл тухайн курсын сургалтын хугацаа нь таарахгүй бол TPS таны төлбөрөө төлсөн байгууллагаас төлбөр буцаан авалт хийхэд тань туслах боломжтой.

Уг төлбөрийг TPS **зарцуулагдаагүй төлбөр** гэнэ.

Та тухайн байгууллагат төлсөн сургалтын төлбөр болон сургалтын төлбөрийн задаргааг харуулсан санхүүгийн баримт (хэрэв боловсрол зуучийн байгууллагат төлсөн бол түүнийгээ хавсаргана) - уудыг TPS-д илгээх шаардлагатай. Эдгээр таны төлбөр буцаан авалтыг тооцоолох үндсэн баримт бичгүүд болно.



TPS таны буцаан авах төлбөрийн хэмжээг тооцоолосны дараагаар таны төлбөр буцаан авах банкны мэдээллээ TPS Онлайнд оруулахыг асуусан емэйл танд илгээнэ.

Та TPS Онлайнд банкны мэдээллээ оруулна. TPS таны мэдүүлсэн банкны дансанд таны зарцуулагдаагүй сургалтын төлбөрийг буцаан оруулах болно.



Хэрэв та гадаад оюутан бол **та** Австрали Улсад үргэлжлүүлэн суралцахын тулд оюутны визнийхээ шаардлагын дагуу гурван сарын дотор өөр боловсролын үйлчилгээ үзүүлэгч байгууллагат бүртгүүлэх шаардлагатай.

Та Австрали Улсад үргэлжлүүлэн суралцана.

Цахим хуудас: www.tps.gov.au | Емэйл: support@tps.gov.au | Утас: [1300 131 798](tel:1300131798)